НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР

# 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2023.01.03

## ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**1.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудын хэрэгжилт:**

1.1.1 Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.2 Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох судалгаа явуулах ажлын хүрээнд:

1.2. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт:

1.2.1 Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулах ажлын хүрээнд:

**1.3. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:**

1.3.1 Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгодыг нийтийн тээврийн сүлжээнд холбох ажлын хүрээнд

1.3.2 Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулах ажлын хүрээнд:

1.3.3 Бодлогын баримт бичиг, стандарт , дүрэм журамд санал өгөх ажлын хүрээнд:

1.3.4 Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн програм хангамжид хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд:

1.3.5 Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

1.3.6 Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд:

1.3.7 Салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн тухай:

### ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Орлогын төлөвлөгөөг улирал бүрээр батлуулан мөрдүүлэх ажлын хүрээнд:
2. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:

### ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа:
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, архив, албан хэрэг хөтлөлт
3. Шинэ замын төлөвлөлт, замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын зурагт нийтийн тээврийн үйлчилгээний зориулалтын автобусны зогсоол байгуулах, байршлыг өөрчлөх тухай санал тусгуулах ажлын хүрээнд:
4. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс чиглэл, зогсоол өөрчлөх, нээх, хаах талаар холбогдох судалгаа хийж, төлөвлөлтийн санал боловсруулж танилцуулж, шийдвэрлүүлэх ажлын хүрээнд:
5. Такси дуудлагын төв, жолоочийг бүртгэлжүүлэх:
6. Нийтийн тээврийн чиглэл, маршрутын талаар:
7. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйлчилгээний цаг рейсийн нэгдсэн даалгаврыг сар бүр боловсруулах талаар:
8. Салбарын техник эдийн засгийн үзүүлэлтийг гарган батлуулах ажлын хүрээнд:

9. Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд:
    10. Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолын тохижилтын ажлын хүрээнд:
    11. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд:

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

1. Байгууллагын чиг үүрэгт хамаарах мэдээллийг цахим хуудсанд тогтмол байршуулж, холбогдох аж нэгж, байгууллагууд болон иргэдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд:

## ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

1. Цаг үеийн шаардлагаар зохион байгуулах ажлын хүрээнд:
2. Сар шинийн баярын үйлчилгээтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:
3. “Улаанбаатар-2023” Зүүн Азийн залуучуудын наадам, “Улаанбаатар марафон-2023”, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:
4. Албан томилолтын тухай:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/844 дугаар захирамжаар тус газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан. Уг захирамжаар зохион байгуулалтын бүтцийг 7 хэлтэс, 1 тасаг, 1 төвтэй 350 хүртэл орон тооны хязгаартай ажиллахаар баталсан.

Дээрх захирамжийг үндэслэн Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/24 дугаар тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн баталлаа. Уг бүтцээр Захиргаа, удирдлагын хэлтэс 18, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс 10, Тээвэр, төлөвлөлтийн хэлтэс 12, Зорчигч, тээврийн үйлчилгээний хэлтэс 13, Ачаа тээвэр, логистикийн хэлтэс 8, Техник, технологийн хэлтэс 13, Хяналт шалгалтын хэлтэс 276 нийт 350 хүний орон тоотойгоор батлагдан үйл ажиллагаагаа явуулж байна.




## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудын хэрэгжилт



*1.1.1 Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:*

Бүгд Найрамдах Франц Улсын “Пома групп” болон “Эжис Рейл” компанийн хамтарсан түншлэл нь 2022 оны 11 дүгээр сард Дүүжин тээврийн 2 дугаар шугам буюу Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хар хорин автобусны буудал" 4.2 км урттай чиглэлийг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх ажлын хүрээнд “Пома групп” болон “Эжис Рейл” компанийн хамтарсан түншлэл нь техник эдийн засгийн

үндэслэлийг боловсруулах ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын явц 80 хувьтай байгаа талаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл”-өөс зохион байгуулсан уулзалтад мэдээлэл өгсөн. Уг төслийн хоёрдугаар шугамыг эцэслэн тохирсон бөгөөд газрын асуудал бүрэн шийдвэрлэгдэж, төслийг эхлүүлэхээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Мөн “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсруулж буй стандартын төсөлтэй танилцаж санал боловсруулан Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/02/1100 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

“Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”- ийн 2 дугаар шугам буюу Энхтайваны өргөн чөлөөг Наадамчдын гудамжтай холбосон 2 буудал бүхий “Хар хорин автобусны зогсоол - Яармаг шинэ Хотын захиргаа” чиглэлийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж Зам тээврийн хөгжлийн яамны Шинжлэх Ухаан Техникийн дэд зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан.




## 1.1.2 Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох судалгаа явуулах ажлын хүрээнд:



2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Зам тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхиийн ерөнхий газар, Шинэ нисэх буудлын захиргаа, Зам тээврийн хөгжлийн төвтэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж чиглэлийн үйлчилгээг хэвийн явуулахад шаардлагатай арга хэмжээний тухай хэлэлцсэн. Улаанбаатар-Хөшигийн хөндийн Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх талаар Зам тээврийн хөгжлийн төвд 2023 оны 02 дугаар сарын 24-ны 2/252 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тухайн чиглэлд үйлчлэх тээврийн хэрэгслийг төлбөрөөс чөлөөлсөн. Мөн Нисэх буудлын нийтийн тээврийн

үйлчилгээг зохион байгуулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад шаардлагатай зардлын санхүүжилтийг тооцоолон боловсруулж 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02/828 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажилласан.

| № | Чиглэл № | Чиглэлийн нэр | Тээврийн хэрэгслийн тоо | | 1 өдөрт ажиллах цаг | | Зардал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажил | Амралт | Ажил | Амралт | 1 өдөр | 1 сар | 1 жил |
| 1 | АЭ:1 | "Чингис хаан ОУНБ-Драгон авто вокзал" | 4 | 4 | 60:00 | 60:00 | 3,201,840 | 96,055,200 | 1,152,662,400 |
| 2 | АЭ:2 | "Чингис хаан ОУНБ-Төмөр замын төв вокзал" | 4 | 4 | 60:00 | 60:00 | 3,201,840 | 96,055,200 | 1,152,662,400 |
| 3 | АЭ:3 | "Чингис хаан ОУНБ-Буянт-Ухаа спорт цогцолбор" | 4 | 4 | 60:00 | 60:00 | 3,201,840 | 96,055,200 | 1,152,662,400 |
| 4 | АЭ:4 | "Чингис хаан ОУНБ-Баянзүрх авто вокзал" | 4 | 4 | 60:00 | 60:00 | 3,201,840 | 96,055,200 | 1,152,662,400 |
| ***Дүн*** | | | ***28*** | ***16*** | ***240:00*** | ***240:00*** | ***12,807,360*** | ***384,220,800*** | ***4,610,649,600*** |

Нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэл нээх ажлын хүрээнд: Нисэх буудлын буухиа чиглэл:5 "Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбай", Нисэх буудлын буухиа чиглэл:6 "Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Зүүн 4 зам" чиглэл тус газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/75 дугаарын тушаалаар батлагдсан. Нисэх буудлын буухиа чиглэл:5 "Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбай" чиглэлд Зорчигч тээвэр Гурав ОНӨААТҮГ-н 2 тээврийн хэрэгсэл 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 10-ны хүртэлх хугацаанд 586 зорчигч тээвэрлэсэн.

1.2 Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт:

**Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт**

1.2.1 Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулах ажлын хүрээнд:

“Хүүхдийн автобусны үйлчилгээг зохицуулах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар захирамжаар “Хүүхдийн сургуулийн автобус”-ны үйлчилгээний чиглэлийг баталж, тээвэрлэлтийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавьж ажиллахыг тус газарт үүрэг болгосон.

Дээрх үүргийн дагуу тус газар нь 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Хүүхдийн сургуулийн автобус”-ны үйлчилгээг эхлүүлэх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өгөх уулзалтыг Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдийг хамруулсан уулзалтыг зохион байгуулан ажилласан.




Мөн Тээвэр, төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 2023 оны 03 дугаар сарын 15, 20, 21-ний өдрүүдэд дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтсийн холбогдох албан хаагчдад дүүргүүдэд хуваарилагдсан хүүхдийн сургуулийн автобусны үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын явцтай танилцаж, өмчлөлийн хэлбэрийг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлж улсын дугаар авах, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгуулах ажилд дэмжлэг үзүүлж, заавар зөвлөгөө өгч ажилласан.






Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110, А/546 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар сургуулийн автобусны үйлчилгээний 69 чиглэлд нийслэлийн 9 дүүрэг, 2 аж ахуйн нэгж, байгууллагын 58 хүүхдийн автобусаар 19926.5 рейс гүйцэтгэж 933641 сурагч тээвэрлэсэн байна.

| Он | Сар | ААНБ-ын тоо | Чиглэлийн тоо | Сургуулийн тоо | Тээврийн хэрэгслийн тоо | Ажилласан өдөр | Гүйцэтгэсэн рейс | Тээвэрлэсэн хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 | 2 | **7** | 23 | 28 | 23 | 11 | 505.5 | 35,783.0 |
| | 3 | 9 | 28 | 28 | 26 | 22 | 1,067.0 | 90,053.0 |
| | 4 | 9 | 37 | 26 | 26 | 16 | 827.5 | 71,737.0 |
| | 5 | 9 | 26 | 30 | 26 | 22 | 1,139.5 | 96,556.0 |
| | 6 | 9 | 26 | 30 | 26 | 7 | 298.5 | 14,395.0 |
| | 9 | 3 | 23 | 23 | 23 | 20 | 901.5 | 74,431.0 |
| | 10 | 3 | 23 | 23 | 23 | 21 | 956.5 | 86,994.0 |
| | 11 | 3 | 23 | 23 | 23 | 15 | 653.5 | 62,905.0 |
| | 12 | 3 | 22 | 22 | 22 | 12 | 517.5 | 48,423.0 |
| **2022 оны дүн** | | | | | | **146** | **6,867.0** | **581,277.0** |
| 2023 | 1 | 2 | 19 | 22 | 22 | 18 | 729.0 | 64,224.0 |
| | 3 | 2 | 19 | 22 | 19 | 18 | 681.0 | 59,995.0 |
| | 4 | 11 | 69 | 86 | 57 | 20 | 1,939.5 | 149,890.0 |
| | 5 | 11 | 69 | 86 | 58 | 23 | 4,531.0 | 165,302.0 |
| | 6 | 4 | 21 | 43 | 21 | 6 | 286.0 | 4,606.0 |
| | 9 | 11 | 56 | 51 | 56 | 20 | 4,076.0 | 163,664.0 |
| | 10 | 11 | 58 | 56 | 58 | 22 | 4,381.0 | 190,526.0 |
| | 11 | 11 | 53 | 56 | 53 | 16 | 3,303.0 | 135,434.0 |
| **2023 оны дүн** | | | | | | **143** | **19,926.5** | **933,641.0** |

Сургуулийн автобусны үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд чиглэл маршрутын саналыг баталгаажуулж ирүүлэх тухай 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2/461 дугаартай албан бичиг Нийслэлийн Боловсролын газарт, 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2/434 дугаартай албан бичиг 9 дүүргийн Засаг даргын Тамгын газруудад тус тус хүргүүлэн ирүүлсэн саналыг нэгтгэсэн.

Тус газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар Нийслэлийн Ерөнхий Боловсролын нийт 55 сургуулийн 49 чиглэлийн замналыг баталсан.









Нийслэлийн боловсролын газраас 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 6/1521 дугаартай албан бичгээр сургуулийн автобус явах шаардлагатай сургуулиудын судалгааг Нийслэлийн Боловсролын газраас ирүүлсэн саналын дагуу 2023-2024 оны хичээлийн жилд Сургуулийн автобусаар 70 сургуулийн 71 чиглэлд 72 автобусаар үйлчилгээ хүргэхээр тус газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/84 дүгээр тушаал батлагдсан. Үүнд: Зорчигч тээврийн нэгтгэл-7 чиглэлд 7 автобус, Зорчигч тээвэр гурав- 5 чиглэлд 5 автобус, Чингэлтэй дүүрэг- 6 чиглэлд 7 автобус, Сүхбаатар дүүрэг- 7 чиглэлд 7 автобус, Хан-Уул дүүрэг- 8 чиглэлд 8 автобус, Баянзүрх дүүрэг- 10 чиглэлд 10 автобус, Баянгол-дүүрэг 7 чиглэлд 7 автобус, Сонгинохайрхан- дүүрэг 16 чиглэлд 16 автобус, Налайх дүүрэг-2 чиглэлд 2 автобус, Багануур дүүрэг- 2 чиглэлд 2 автобус, Багахангай дүүрэг- 1 чиглэлд 1 автобусаар 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулсан.

### 1.3. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

*1.3.1 <u>Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгодыг нийтийн тээврийн сүлжээнд холбох ажлын хүрээнд:</u>*




Нийслэлийн алслагдсан Багануур дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг үндэслэн буухиа үйлчилгээний их багтаамжийн автобусны БУ17а "Улаанбаатар /Офицеруудын ордон/-Багануур /Хэрлэн худалданы төв/" чиглэлийг шинэчлэн 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 дугаар тушаалаар батлуулсан.

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/1396 дугаартай албан бичгээр Чингис хаан нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг нээх хүсэлтийн дагуу иргэдийн эрэлт хэрэгцээг хангах, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд зорчигч тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор

2023 оны 07 дугаар сарын 03-ний өдрөөс ЭКС:1 “Чингис хаан нисэх онгоцны буудал-120 мянгат-Баруун 4 зам” чиглэлийг нээж 2023 оны 09 дүгээр сарын 10 хүртэлх хугацаанд 586 зорчигч тээвэрлэсэн.




## 1.3.2 *Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулах ажлын хүрээнд:*

Баянзүрх дүүргийн 25, 26 дугаар хороодод 2023 оны 1 дүгээр сарын 21- нд дүүргийн тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 4 байршилд автобусны замналын дундын зогсоол төлөвлөж орон нутгийн хөрөнгөөр хийлгэхээр шийдвэрлэсэн.

Ерөнхий менежерийн 2023 оны А/45 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж нийтийн бие засах газар болон барилга байгууламжтай 6 эцсийн зогсоол, нийтийн тээврийн үйлчилгээний тохижилт хийгдсэн зогсоолуудын арчлалт ашиглалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн аж ахуй нэгжид хариуцуулахаар тендер зарлан сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж Дижитал концефт ХХК (GS-25)-нд Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэн 5 зогсоолыг хүлээлгэн өгсөн бөгөөд Баянхошууны эцсийн зогсоол 2023 оны 09 дүгээр сарын 13, Дэнжийн 1000-н эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 14, Шар хадны эцсийн зогсоол







2023 оны 08 дугаар сарын 31, Нисэхийн эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр тус тус ашиглалтанд орсон. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/667 тушаалаар

нийтийн бие засах  газрын автобусны зогсоолын үйлчилгээ чанарыг сайжруулах иргэдийн эрүүл цэвэр, тухтай орчинд зорчих нөхцөлийг бүрдүүдлэх захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан  ажлын хэсгийн хуралд Нийслэлийн захирагчийн ажлын албанд 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөр хуралд оролцон ажилласан.




П.Гэндэнгийн гудамжинд 2 байршилд шинээр автобусны зогсоол байгуулж Ч:30 чиглэлийн тээврийн хэрэгсэл зогсох нөхцөл бололцоог хангуулж тэмдэг тэмдэлгээний ажлыг холбогдох байгууллагуудаар хийлгэсэн.




Баянзүрх дүүрэг Шар хад чиглэлийн автобусны 2 дугаар буудлын 2021 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр тохижуулсан ажлын барьцаа хөрөнгийг барилгын тухай хуулийн 14.1 заасаны дагуу газар дээр нь үзлэг шалгалт хийн чөлөөлсөн.




2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сард Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран уулзалт зохион байгуулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 01/02/811 дугаарын бичгээр хүргүүлсэн. Тус ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж “Геозураглал” ХХК, “Монголиан Нэйшнэл

Хайвэй" ХХК-иудын түншлэл шалгарсан бөгөөд нийтийн тээврийн 1 загварын 2 терминал байгуулах суурь судалгааны ажил болон оптофотограф хийх ажил эхэлсэн. Хоёр байршлын 5 цэгт дэвсгэр зураг төслийг гүйцэтгүүлэн авсан. Дээрх ажлын хүрээнд зорчигч тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах, сонгох газар чөлөөлөх асуудлаар Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай хамтран ажиллаж байна.



Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт шинээр байгуулсан 2 автобусны зогсоолын байгууламжийг нийслэлд хүлээлгэж өгөх хүсэлтийн дагуу хүлээн авах комисст 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр ажиллаж санал өгсөн.



Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн автобусны зогсоолын шилэн самбар эвдэрч сүйдсэнийг засварлах болон эзэн холбогдогчийг тогтоох ажлыг зохион байгуулсан.









П.Гэндэнгийн гудамжинд 2 байршилд шинээр автобусны зогсоол байгуулж Ч:30 чиглэлийн тээврийн хэрэгсэл зогсох нөхцөл боломцоог хангуулж тэмдэг тэмдэлгээний ажлыг холбогдох байгууллагуудаар хийлгэсэн.





Баянзүрх дүүрэг Шар хад чиглэлийн автобусны 2 дугаар буудлын 2021 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр тохижуулсан ажлын барьцаа хөрөнгийг барилгын тухай хуулийн 14.1 заасаны дагуу газар дээр нь үзлэг шалгалт хийж чөлөөлсөн.





2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын

санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сард Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран уулзалт зохион байгуулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 01/02/811 албан тоотоор хүргүүлсэн. Тус ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж, 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж, хамтран ажиллах компани сонгон шалгаруулж ажиллаж байна.



Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт шинээр байгуулсан 2 автобусны зогсоолын байгууламжийг нийслэлд хүлээлгэж өгөх хүсэлтийн дагуу хүлээн авах комисст 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр ажиллаж санал өгсөн.



Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хорооны нутаг дэвсгэр байрлах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн автобусны зогсоолын шилэн самбар эвдэрч гэмтсэнийг засварлах болон эзэн холбогдогчийг тогтоох ажлыг зохион байгуулсан.





Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн А/1311 дүгээр захирамжаар батлагдсан авто зам, замын байгууламж шинээр барих болон өргөтгөл шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байгаатай холбоотойгоор нийслэлийн 5 дүүргийн 41 хорооны нутаг дэвсгэрт хийгдэх, шинэчлэх автозамын 41 байршлын ажлын зураг төсөлд санал өгөхөөр холбогдох судалгааг хийн Нийслэлийн Замын хөгжлийн газартай хамтран ажиллаж байна.

Жи Ар Си ХХК-ний боловсруулсан Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд байрлах Улиастайн 1.78 км авто замд 2/525 дугаартай албан бичгээр, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах 0.9 км автозамын зураг төсөлд 2/526 дугаартай албан бичгээр нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолыг тусгуулахаар санал өгсөн.



Жи АР Си ХХК-ны боловсруулсан Нийслэлийн төвийн 6 дүүрэгт шинээр хийгдэх авто замын Баянзүрх дүүргийн 11.23 дугаар хороо 0.09.1.78у/м авто зам Хан-Уул дүүрэгт 3.20 дугаар хорооны нутаг дэвсгэрт "LRT" төсөл Сонгинохайрхан дүүрэгт 42.37 дугаар хороо мөн Дөрвөн тэнхлэг ХХК-ны боловсруулсан 15 дугаар хороонд шинээр хийгдэх авто зам болон Гео зураглал ХХК-ны боловсруулсан Сонгинохайрхан дүүргийн 2 болон 24 дүгээр хороод мөн Ангад аривжих ХХК-ны Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр хийгдэх авто замын зураг төслүүдэд санал хүргүүлсэн.




| Д/Д | ТОДОРХОЙЛОЛТ | ТАЙЛБАР |
|---|---|---|
| 1 | СХД-ийн 152 дугаар сургууль | Одоо байгаа |
| 2 | СХД-ийн 253 дугаар цэцэрлэг | Одоо байгаа |
| 3 | СХД-ийн 26 дугаар хороо | Одоо байгаа |
| 4 | Төлөвлөж буй авто замын зогсоол | Шинээр хийх |
| 5 | Төлөвлөж буй авто замын эхлэл | Шинээр хийх |
| 6 | Төлөвлөж буй авто замын төгсгөл | Шинээр хийх |

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны иргэдийн санал хүсэлтийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн А/06 тушаалын хавсралтаар нийтийн тээврийн үйлчилгээний ХО:10А "Хүй 7 худаг – Эмээлт /хурган/" чиглэлийг шинээр нээж,




Нийслэлийн алслагдсан Багануур дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг үндэслэн буухиа үйлчилгээний их багтаамжийн автобусны БҮ17а Улаанбаатар /Офицеруудын ордон/-Багануур /Хэрлэн худалданы төв/ чиглэлийг шинэчлэн А/05 дугаар тушаалаар 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс;

Нийтийн тээврийн газрын 2023 оны .... дугаар сарын ....-ний
өдрийн А/... дугаар тушаалын хавсралт




Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 36 дугаар хорооны иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор "Ч63 "Хан хилсс хотхон-Ривер гарден-Баянмонгол хороолол-МУБИС-Ард кино театр" чиглэлийг Ч63А "Хан хиллс хотхон-Ривер гарден-МУБИС-Ард кино театр" болгон өөрчилж нэгдүгээр, Ч63Б "Дүнжингарав худалдааны төв-Баянмонгол хороолол-Төв номын сан" болгон 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/12 дугаар тушаалаар өөрчилж 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс;







Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хороо, Шинэ яармаг, Буянт-Ухаа 2 хорооллын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/23 тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээний Ч:75 "Архивын ерөнхий газар – Сонсголон – 5 шар" чиглэлийг шинээр нээж;




Хан-Уул дүүргийн 8, 9, 16, 21 25 дугаар хороодын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/40 тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээний Ч:76 "Нисэх – ТЭЦ-4 – 3,4-р хороолол" чиглэлийг шинээр нээж,




Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Сэлбийн иргэдийн нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах, дамжин суух нөхцлийг бүрдүүлэх үүднээс 2023 оны А/39 дүгээр тушаалаар Ч:29 "Сэлбэ амралт - МУБИС – Вокзал" чиглэлийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Ч:29А "Сэлбэ амралт-Сансар-Зүүн 4 зам", Ч:29Б "Зүүн 4 зам-Сансар-Вокзал" чиглэлүүдийн үйлчилгээг эхлүүлсэн хэдий ч иргэдийн санал хүсэлтийн дагуу 2023 оны А/61 дүгээр тушаалаар Ч:29А "Сэлбэ амралт-Сансар-Зүүн 4 зам" чиглэлийг Ч:29А "Сэлбэ амралт-Сансар тойрог-Хөгжим бүжиг коллеж- Өргөө амаржих газар" болгон өөрчлөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс;







Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Зайсан толгойг тойрсон авто замыг хэсэгчлэн нэг чигийн хөдөлгөөнд оруулсантай холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээний Ч42 "Сүлжмэл-Нарны гүүр-Зайсан", Ч45 "Ган хийц-ХМК-Зайсан", Ч55 "Зайсан-Дэнжийн 1000-Засгийн газрын авто бааз-Согоотын гудамж", Ч65 "Зайсан-Офицеруудын ордон", Ч66 "Зайсан-Цэцэг төв-11-р хороолол", Ч72 "Богдхан амралт-Ар зайсангийн гудамж-Сүхбаатарын талбай" чиглэлүүдэд 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 тушаалаар өөрчилж 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс; Зуны улирал эхэлсэнтэй холбогдуулж Улаанбаатар хотын иргэдийн шөнийн цагаар зорчих эрэлтийг хангасан, аюулгүй, найдвартай тээврийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/68 тушаалаар ШҮ:1 "5 шар - Сүхбаатарын талбай", ШҮ:2 "Сүхбаатарын талбай-Ботаникийн эцэс", ШҮ:3 Шархад - 3,4-р хороолол", ШҮ:4 "3,4-р хороолол - Өнөр хороолол-ХМК", ШҮ:5 "Зунжин худалдааны төв - Ард кино театр", ШҮ:6 "МУБИС – Архивын Ерөнхий газар" чиглэлийг шинээр нээж;







Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/75 тушаалаар Нисэх буудлын буухиа чиглэл:5 "Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбай", Нисэх буудлын буухиа чиглэл:6 "Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Зүүн 4 зам" чиглэлийг шинээр нээж;




Сонгинохайрхан дүүргийн 24,25 дугаар хороо, Баруунсалааны эцсийн зогсоолоос 3.8 км, Зүүнсалааны эцсийн зогсоолоос 2 км авто зам шинээр тавигдсантай холбогдуулан тус хорооны иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, зорчих эрэлтийг хангах зорилгоор 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/83 тушаалаар Ч:16 "Баруунсалаа-10-р хороолол" чиглэлийг Ч:16 "Баруунсалаа /Нумтын ам-10-р хороолол" болгон чиглэлийн замналд өөрчлөлт оруулан, шинээр Ч:3А "Зүүнсалааны шинэ эцэс-Халдвартын эмнэлэг" чиглэлийг нээж;







Хан Уул дүүргийн 5,6 дугаар хороо, Наадамчдын замын чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг тусгаарласантай холбогдуулан 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Ч:77 "Нисэх-Яармаг-120 мянгат" чиглэлийг шинээр нээж;



Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж, иргэдийн зорчих эрэлт хэрэгцээг хангах үүднээс 2023 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн А/95 дугаар тушаалаар ХО:6 “Өлзийт хороолол – Яармаг” чиглэлд зогсоол нэмж,




2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/102 тушаалаар Ч:22 “Шадивлан эцэс -Бөмбөгөр - Чингис Соосэ ДС-Далангийн зам”, Ч:22өв “Шадивлан -Бөмбөгөр - Чингис Соосэ ДС-Далангийн зам”, Ч:23 “Чингэлтэй /Зүрх уул/ – МУБИС – Цэцэг төв", Ч:24А “ЗҮРХ УУЛ /Чингэлтэй/ - 3,4-Р ХОРООЛОЛ /эцэс/", Ч:27 “Вокзал – Бөмбөгөр – Өвөр согоот", Ч:28 “Сэлх – 7 буудал – Ард кино театр", Ч:33 “Шар хад – 7 буудал – Зунжин худалдааны төв", Ч:73 “Зунжин худалдааны төв - ТЭЦ 4", ХО:1 “Санзай – 7 буудал – Тэнгис кино театр", ХО:2 “Шарга морьт – Дүнжингарав худалдааны төв", ЗҮ:1 “Гүнт - Жигжид - Тэнгис кино театр”, ЗҮ:2 “Гоодой - Тэнгис кино театр”, ЗҮ:3 “Баянбулаг - Тэнгис кино театр”, ШҮ:5 “Ард кино театр - Зунжин худалдааны төв” чиглэлүүдийн зогсоолын нэршилд өөрчлөлт оруулсаны тухай бүрт тушаалын зураглалыг боловсруулан, мэдээллийг шинэчлэн чиглэлийн паспорт хөтлөн баяжилт хийж;




Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор 2023 оны 12 дугаар сарын

07-ны өдрийн А/113 тушаалаар ХО:10 “Эмээлт /хурган/ – 5 шар” чиглэлд нэгдүгээр, ХО:10А “Хүй 7 худаг - Эмээлт /хурган/ - 5 шар” чиглэлд хоёрдугаар, ХО:12 “Мал бордох – 5 шар” чиглэлд гуравдугаар, ХО:13 “Баруун түрүү – 5 шар” чиглэлд дөрөвдүгээр, ХО:14 “Жаргалант тосгон/Партизан/ – Хархорин худалдааны төв” чиглэлд Товчооны зам 1-р зогсоол /хойд, урд/, Товчооны зам 2-р зогсоол /хойд, урд/, Товчооны зам 3-р зогсоол /хойд, урд/, Товчооны зам 4-р зогсоол /хойд, урд/, Товчооны зам 5-р зогсоол /хойд, урд/, Товчооны зам 6-р зогсоол /хойд, урд/ чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолуудыг ашиглалтад оруулж







тус тус мөрдүүлэн ажилласан.

### 1.3.3. *Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн програм хангамжид хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд*

2023 онд системд Газрын даргын А/42 тушаалаар батлагдсан журам, аргачлалын 6 заалтад оруулсан нэмэлт өөрчлөлт болон системд сайжруулалт хийх нийт 5 төрлийн ажлыг хэрэглэгчийн шаардлага хүргүүлэн хөгжүүлэлт хийлгэсэн. Үүнд:




- Нэг тээврийн хэрэгсэл 1 удаа эх авах
- Журмын 3.1.4, Аргачлалын 1, 8, 10.1, 11.2, 18.1 дүгээр заалтуудын хөгжүүлэлтийг нэмэлт хөгжүүлэлт хийх, залруулах
- Зогсоол хоорондын хугацааг өөрчлөх цэсийн хөгжүүлэлт
- Төхөөрөмж, GPS-ийн алдаанаас шалтгаалан үүссэн зөрчлийн тоог зөрчлийн тайлангаас хасаж гаргах
- Эх авалт оройн буултын тайлан зэрэг болно.

Тайлант хугацаанд удирдлага мэдээллийн системд эдгээр хөгжүүлэлтийн ажлуудыг хийлгэхээр 8 удаагийн албан бичгээр Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлж хэрэглэгчийн шаардлага нэмэлт мэдээллийг хүргүүлсэн.

### 1.3.4. *Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:*

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн 6.1 дэх заалтад (Нийслэлийн Засаг дарга замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарыг тогтоож, уг бүсэд мөрдөх журмыг батална) гэж заалтын хүрээнд ачаа тээвэртэй холбоотой үйл

ажиллагаа журам холбогдон гарах талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс тайлбар өгөөд байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх иргэн, ААНБ-уудын тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, ачаа тээврийн тээвэрлэлтийн мэдээллийн санг үүсгэх, тээвэрлэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор түр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл” хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим систем”-ийг ашиглан түр зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, тохирох ангиллын зөвшөөрөл олгож байна. Цахим үйлчилгээнд шилжсэнээр зөвшөөрөл авсан тээврийн хэрэгслийн мэдээллийг цахимаар шалгах, хяналт тавих боломжтой болсон.

“Түр” зөвшөөрлийн программ дараах үндсэн 4 бүтэцтэйгээр хөгжүүлэлт хийгдсэн.

1.Зөвшөөрөл хүссэн тээвэрчид материалаа цахимаар илгээх;

2.Зөвшөөрөл авахаар ирүүлсэн материалыг цахимаар шалгах;

3.Зөвшөөрлийн хураамжийг цахимаар төлөх нөхцөлийг бүрдүүлэх;

4. Зөвшөөрөл авсан ачааны автомашины машины мэдээллийг цагдаагийн багаж дээр гаргах зэрэг ажлууд хийгдсэн.

Мөн түр зөвшөөрөл авах хүсэлт баталгаажсан тохиолдолд иргэн аж ахуй нэгж зөвшөөрлийг өөрсдөө хэвлэн авах боломж бүрдсэн.




2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим систем”-ийг ашиглан түр зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч 2023 оны 11 дугаар сарын 14-ны байдлаар 5636 ачааны автомашинд “Түр” зөвшөөрлийг олгож ажилласан.

Нийслэлийн ачаа тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Журмын хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт хийж буй ачааны төрлийн автомашинуудад “ЕС” зөвшөөрөл болон хориглосон гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл олгох ажлыг холбогдох стандарт, дүрэм, журмыг хангуулан зохион байгуулж ажилласан.

“Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалтайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Түр” зөвшөөрлийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smartcar.mn сайтаар олгох ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 02 өдрөөс эхлүүлсэн.




**Зураг №12** *АЧАА ТЭЭВРИЙН ТҮР ЗӨВШӨӨРӨЛ ЦАХИМААР АВАХ ЗӨВЛӨМЖ*

А.Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ноос 2023 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 5636 зөвшөөрөл олгосон. Үүнээс В ангиллын 1157, С ангиллын 4127, СЕ ангиллын 352 тээврийн хэрэгсэлд олгож төрийн санд 966.866,500 төгрөг төвлөрүүлсэн.

**Хүснэгт №1** **2023 ОНД ОЛГОСОН “ТҮР” ЗӨВШӨӨРЛИЙН ТОО**

| д/д | Эзэмшигч | Хүлээн авч, олгосон | Орлого /мян.төг/ |
|---|---|---|---|
| | **В ангилал** | | |
| 1 | Байгууллага | 1098 | 146,494.000 |
| 2 | Иргэн | 59 | 7,479.000 |
| | Ангиллын дүн | 1157 | 153,973.000 |
| | **С ангилал** | | |
| 3 | Байгууллага | 3319 | 631,822.500 |
| 4 | Иргэн | 808 | 112,779.000 |
| | Ангиллын дүн | 4127 | 744,601.500 |
| | **Е ангилал** | | |
| 5 | Байгууллага | 264 | 53,886.000 |
| 6 | Иргэн | 88 | 14,406.000 |
| | Ангиллын дүн | 352 | 68,292.000 |
| | **Нийт дүн** | **5636** | **966,866.500** |

**2022-2023 ОНУУДАД ТҮР ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АВТОМАШИНЫ ТОО, ХАРЬЦУУЛАЛТ**




Б. “Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрөл”-ийг Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машинаар олгох, мэдээ тайланг нэгтгэж ажиллах.





ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГААС ГАРАХ ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН НЭГДСЭН МАЯГТ

Ачааны авто машины ЕС зөвшөөрөл

С
Hyundai Hyundai HD080
24200
2023 оны 1-р хагас жил

ТҮЦ машинаар “ЕС” зөвшөөрөл олгохдоо тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаж тэнцсэн эсэх, татвар төлсөн эсэхийг хянасны үндсэн дээр зөвшөөрлийг олгон, мөн ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс ачаа тээврийн ажил гүйцэтгэлийн тайлан мэдээг “Нийслэлийн тээврийн газрын тайлангийн нэгдсэн систем”-ээр дамжуулан авч байна.

***Зураг №13** ТҮЦ МАШИНААР “ЕС” ЗӨВШӨӨРӨЛ*

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрлийг 12 дугаар 21-нээс 2023 оны 05 дугаар сарын 31 хүртэл нийт 17561 тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 8879, С ангиллын 7847, СЕ ангиллын 835 тээврийн хэрэгсэлд тус олгож, төрийн санд 223.195,000 төгрөг төвлөрүүлсэн.

**Хүснэгт №2** "ЕС" ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АВТОМАШИНЫ ТОО

| Ангилал | Тээврийн хэрэгслийн Тоо | Орлого /мян.төг/ |
|---|---|---|
| В ангилал | 8879 | 88,790.000 |
| С ангилал | 7847 | 117,705.000 |
| Е ангилал | 835 | 16,700.000 |

| | | |
|---|---|---|
| **Нийт** | **17561** | **223,195.000** |

***Хүрсэн үр дүн***: Нийт 1.190.061.500 төгрөг төвлөрүүлж, түр зөвшөөрөл өмнөх онтой харьцуулахад 8.4 % өссөн үзүүлэлттэй, ЕС өмнөх онтой харьцуулахад 4.8% буурсан байна.

Түр зөвшөөрлийн загвар /2023 оны 01 дүгээр хагас/




ТҮР ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАР /2023 ОНЫ 02 ДУГААР ХАГАС/




*ОНЫ ТҮР ЗӨВШӨӨРЛҮҮДИЙН ЗАГВАР*

Арга хэмжээ №3.3. Ачаа тээврийн үйл ажиллагааг нийслэлийн гудамж замын ачаалалтай уялдуулан зөв, оновчтой хэлбэрээр зохион байгуулах. /ХЧҮ-2.

Арга хэмжээ №3.3. Ачаа тээврийн үйл ажиллагааг нийслэлийн гудамж замын ачаалалтай уялдуулан зөв, оновчтой хэлбэрээр зохион байгуулах. /ХЧҮ-2.4/

1.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зохицуулалт хийх замаар замын хөдөлгөөний

түгжрэл, саатлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг хязгаартайгаар оролцуулах журам”-ыг шинэчлэн боловсруулсан. Зарим шаардлагатай гудамж, замыг тэмдэг, тэмдэглэлээр зохицуулах, түүнчлэн төв замын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсантай холбоотойгоор зарим төрлийн үйл ажиллагааг цагийн хязгаартайгаар оролцуулахаар зохицуулалт оруулсан.

2.Зам, тээврийн хөгжлийн яам, Тээврийн цагдаагийн алба, Зам тээврийн хөгжлийн төв, Нийтийн тээврийн газар, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ хамтарсан “Хүнд овор ихтэй ачаа тээвэрлэлтэд тулгарч буй асуудал” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Тээврийн цагдаагийн албаны байранд зохион байгуулсан.



**Зураг №15** *Тээврийн цагдаагийн алба*
*“Хүнд овор ихтэй ачаа тээвэрлэлтэд тулгарч буй асуудал” зөвлөгөөн*

Уг зөвлөгөөнөөр мэргэжлийн байгууллагууд харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид том оврын ачааны автомашины даац хэтрүүлэн замын хөдөлгөөнд оролцох зөрчлийн улмаас авто замд үүсэж буй эвдрэл, гэмтэл, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандартын хэрэгжилтийг хангуулахад тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, Тээврийн цагдаагийн албанаас “**ЗӨВЛӨМЖ**” гаргаж, хологдох байгууллагуудад хүргүүлэхээр хэлэлцсэн.

3.Нийслэлийн Засаг даргын 2008 оны А/191 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах, автозам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах, авто замын хөлдөлт, гэсэлтийн үед авто замаар зорчуулах тээврийн хэрэгслийн бодит жин, тэнхлэгт дээрх ачаалал, автотээврийн хэрэгслийн стандартын үзүүлэлт, шаардлагад хяналт тавих зорилгоор Тээврийн цагдаагийн алба, Нийтийн тээврийн газар, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран 2023 оны 03 дугаар сарын 27-ноос 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 97 тээврийн хэрэгсэлд хяналт тавьж хариуцлага тооцож ажилласан.



***Зураг №16*** *Хяналт шалгалт явагдаж буй байдал*

Арга хэмжээ №3.4 Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах**.** /ХЧҮ-3.1/

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 31 дүгээр тушаалаар тус газарт Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн,
аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах эрхийг олгосон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", 2016 оны А/90 дүгээр тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар “Харьяалах нутаг дэвсгэрт хамтран хэрэгжүүлэх” 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн 28 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд

БАТЛАВ:
АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫНХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
........................
/Ё.ЖАРГАЛСАЙХАН/

БАТЛАВ:
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
........................
/С.ЖАВХЛАНТБААТАР/

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2016 ОНЫ 76 ДУГААР ТУШААЛЫГ ХАРЬЯАЛАХ НУТАГ ДЭВСГЭРТ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023.04.12

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв, сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2022 ОНЫ А/112 ДУГААР ТУШААЛААР БАТАЛСАН "АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД АНГИЛАЛ ТОГТООХ ЖУРАМ", "ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР ХИЙХ ЖУРАМ"-УУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 1.1. | Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох | - | Ангилал тогтоосон тоо | 2022 онд 29 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 45 ажил үйлчилгээнд ангилал тогтоон, гэрээ байгуулан гэрчилгээ олгосон. | ***Хагас жилийн байдлаар:*** Авто үйлчилгээ эрхлэгч 20 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж ангилал тогтоосон байна. ***Жилийн эцсийн байдлаар:*** Авто үйлчилгээ эрхлэгч 50 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж ангилал тогтоосон байна. | I-IV улирал | НТГ |
| 1.2. | Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тохирлын үнэлгээнд хамруулах. | - | Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо | Автомашины засвар үйлчилгээ эрхлэгч 11 байгууллагын 27 үйлчилгээ тохирлын үнэлгээнд | 2023 оны эхний хагас жилд 5, сүүлийн хагас жилд 10, нийт 15 байгууллагыг тохирлын үнэлгээнд хамруулсан байна. | I-IV улирал | НТГ |

14 арга хэмжээ тусгагдан батлагдаж хэрэгжилтийг ханган ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалыг харьчалах нутаг дэвсгэрт хамтран хэрэгжүүлэн гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/04/1274 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамын Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зам, тээврийн хөгжлийн яамын Хяналт, Үнэлгээ, Дотоод аудитын газарт тус тус хүргүүлэн ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгүүлэх гэрээ”-г 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 4 зорилт 14 арга хэмжээ тусгаснаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар “үр дүнтэй” буюу бэрэн хэрэгжсэн3, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу хэрэгжих шатанд 70 хувьтай 2, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай 2, “үр дүнгүй” буюу 30 хувьтай 3, тасарсан 2, хугацаа болоогүй 2 арга хэмжээ төлвөлөгөөний хэрэгжилт 52,5 хувьтай үнэлэгдсэн.

А.“Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангaн “Онлайн бизнес төв”-өөр дамжуулан нийт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт 84 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч биетээр болон цахимаар стандартын шаардлага хангасан 131 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 318 ажил үйлчилгээнд ангилал тогтоон, ажил үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан.

**АВТО ҮЙЛЧИЛГЭЭ АНГИЛАЛ ТОГТООСОН**
**АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ**

| № | Ажил үйлчилгээний төрөл | Нийт | ААНБ | Иргэн | Баянгол | Баянзүрх | Хан-Уул | Сонгинохайрхан | Чингэлтэй | Сүхбаатар | Багахангай | Багануур | Налайх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агрегат зангилаа механизмын оношлогоо, засвар | 39 | 31 | 8 | 11 | 11 | 1 | 3 | 3 | 10 | | | |
| 2 | Техникийн үйлчилгээ | 24 | 21 | 3 | 4 | 7 | 0 | 2 | 3 | 8 | | | |
| 3 | Хөдөлгүүрийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 33 | 27 | 6 | 9 | 10 | 1 | 2 | 3 | 8 | | | |
| 4 | Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 28 | 21 | 7 | 7 | 10 | 0 | 2 | 3 | 6 | | | |
| 5 | Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DFP, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношлогоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт | 6 | 6 | 0 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 3 | | | |
| 6 | Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 12 | 12 | 0 | 3 | 5 | 1 | 0 | 0 | 3 | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **7** | Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар | 11 | 11 | 0 | 3 | 4 | 1 | 0 | 0 | 3 | | | |
| **8** | Жолооны механизм, явах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 13 | 12 | 1 | 3 | 5 | 1 | 0 | 0 | 4 | | | |
| **9** | Их биеийн засвар | 20 | 12 | 8 | 9 | 5 | 1 | 0 | 2 | 3 | | | |
| **10** | Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ | 38 | 15 | 23 | 12 | 9 | 2 | 6 | 2 | 5 | | | 2 |
| **11** | Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 7 | 7 | 0 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 1 | | | |
| **12** | Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт | 5 | 1 | 4 | 3 | 2 | 0 | 0 | 0 | 0 | | | |
| **13** | Автомашины шил засварлах, суурилуулах үйлчилгээ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | |
| **14** | Автотээврийн хэрэгсэл | 9 | 5 | 4 | 5 | 2 | 0 | 0 | 0 | 2 | | | |
| **15** | Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл | 44 | 30 | 14 | 17 | 10 | 0 | 3 | 4 | 10 | | | |
| **16** | Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал | 23 | 17 | 6 | 5 | 6 | 0 | 1 | 3 | 8 | | | |
| **17** | Оёдол доторлогоо үйлчилгээ | 4 | 3 | 1 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 1 | | | |
| **18** | Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд | 2 | 1 | 1 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | | | |
| **19** | Авто зогсоол | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | |
| **20** | Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | |
| **Нийт** | | **318** | **232** | **86** | **98** | **89** | **9** | **20** | **25** | **75** | | | **2** |

2023 оны нэгдсэн судалгаагаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд авто үйлчилгээ эрхлэгч нийт 1466 иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдсэнээс 972 иргэн, 494 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна.

***Хүснэгт№ 5*** АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНГИЛАЛ ТОГТООЛГОСОН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

| № | Дүүрэг | Нийт | ААНБ | Иргэн |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Баянгол | 50 | 28 | 22 |
| 2 | Баянзүрх | 35 | 21 | 14 |
| 3 | Хан-Уул | 5 | 2 | 3 |
| 4 | Сонгинохайрхан | 8 | 3 | 5 |
| 5 | Чингэлтэй | 8 | 5 | 3 |
| 6 | Налайх | 2 | 1 | 1 |
| 7 | Сүхбаатар | 23 | 15 | 8 |
| Нийт | | **131** | **75** | **56** |

Нийслэлийн 9 дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчид ангиллаа тогтоолгож эрх бүхий байгууллагаас ангиллын гэрчилгээ авсан мэдээллийг /хавсралт 1/

**Хүрсэн үр дүн:** 2023 онд 131 иргэн, аж ахуйн нэгж байгууллага ангилал тогтоолгож өмнөх онтой харьцуулахад 78.6 % өссөн үзүүлэлттэй байна.

Б.Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандартын шаардлага хангуулах, ангилал тогтоох, авто засварын үйлчилгээнд тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэх.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор “Автомашины оношилгоо болон засвар” тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад орсон тул авто үйлчилгээ эрхлэгчид нь “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалт, MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг хангасан байгууллагаар тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэж ангиллаа тогтоолгон үйл ажиллагаа явуулах гэж заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн нутаг дэвсгэрт автомашины засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт 33 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 174 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэн, ангилал тогтоолгоод байна

***ХҮСНЭГТ №6*** 2023 ОНД ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙЙЛГЭСЭН АВТО үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа

| № | Ажил үйлчилгээний төрөл | Нийт | ААНБ | Иргэн | Баянгол | Баянзүрх | Хан-Уул | Сонгинохайрх | Чингэлтэй | Сухбаатар | Багахангай | Багануур | Налайх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агрегат зангилаа механизмын оношлогоо, засвар | 39 | 31 | 8 | 11 | 11 | 1 | 3 | 3 | 10 | | | |
| 2 | Техникийн үйлчилгээ | 24 | 21 | 3 | 4 | 7 | | 2 | 3 | 8 | | | |
| 3 | Хөдөлгүүрийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 33 | 27 | 6 | 9 | 10 | 1 | 2 | 3 | 8 | | | |
| 4 | Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 28 | 21 | 7 | 7 | 10 | | 2 | 3 | 6 | | | |
| 5 | Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DFP, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношлогоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт | 6 | 6 | 0 | 1 | 2 | | | | 3 | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 12 | 12 | 0 | 3 | 5 | 1 | | 3 | |
| 7 | Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар | 11 | 11 | 0 | 3 | 4 | 1 | | 3 | |
| 8 | Жолооны механизм, явах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 13 | 12 | 1 | 3 | 5 | 1 | | 4 | |
| 9 | Их биеийн засвар | | | | | | | | | |
| 10 | Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ | | | | | | | | | |
| 11 | Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 7 | 7 | 0 | 3 | 2 | 1 | | 1 | |
| 12 | Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт | | | | | | | | | |
| 13 | Автомашины шил засварлах, суурилуулах үйлчилгээ | | | | | | | | | |
| 14 | Автотээврийн хэрэгсэл | | | | | | | | | |
| 15 | Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл | | | | | | | | | |
| 16 | Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал | | | | | | | | | |
| 17 | Оёдол доторлогоо үйлчилгээ | | | | | | | | | |
| 18 | Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд | | | | | | | | | |
| 19 | Авто зогсоол | | | | | | | | | |
| 20 | Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах | | | | | | | | | |
| | **Нийт** | **173** | **148** | **25** | **44** | **56** | **6** | **9** | **12** | **46** |

Тохирлын үнэлгээ хийлгэсэн иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг/Хавсралт 2/

**Хүрсэн үр дүн:** 2023 онд 33 иргэн, аж ахуйн нэгж байгууллага ангилал тогтоолгож өмнөх онтой харьцуулахад 33.4 % өссөн үзүүлэлттэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Авто үйлчилгээ”-ний талаарх статистик мэдээ тайланг хагас болон бүтэн жилээр гаргаж яаманд хүргүүлэх;

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын судалгааг 2023 оны хоёрдугаар улирлын тоон мэдээллийг нэгтгэн Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 01/04/1448 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР
Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу 15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас : www.transport.ub.gov.mn

2023.07.28 № 01/04/1448
танай ______ -ны № ______ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Статистик мэдээ хүргүүлэх тухай

Тус газар нь Зам, тээврийн хөгжлийн яамтай 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалыг харьяалах нутаг дэвсгэрт хамтран хэрэгжүүлэх гэрээ"-г байгуулан, гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн талаарх статистик мэдээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/88 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу гарган хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

Нийслэлийн нийтийн тээврийн газар
Газрын дарга
Дарга
Санжаа ЖАВХЛАНТБААТАР
2023.07.28 14:10

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР
Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу 15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас : www.transport.ub.gov.mn

2023.07.28 № 01/04/1449
танай ______ -ны № ______ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАРТ

Статистик мэдээ хүргүүлэх тухай

Тус газар нь Зам, тээврийн хөгжлийн яамтай 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалыг харьяалах нутаг дэвсгэрт хамтран хэрэгжүүлэх гэрээ"-г байгуулан, гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн талаарх статистик мэдээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/88 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу гарган хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

Нийслэлийн нийтийн тээврийн газар
Газрын дарга
Дарга
Санжаа ЖАВХЛАНТБААТАР
2023.07.28 14:12

***Зураг №18*** *Статистик тайлан мэдээг албан бичгээр хүргүүлсэн байдал*

Арга хэмжээ №3.6. Дэвшилтэт техник технологид суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээний бүртгэлийн цогц үйлчилгээ, тээврийн ухаалаг системийг хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.11, Авто үйлчилгээ эрхлэгч байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн баяжилтыг хөтөлж, хяналт тавих: /ХЧҮ-3.3/

"Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн www.autobox.mn веб сайтын программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж "Автомашины оношилгоо болон засвар"-ийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хандах эрхийг өгч авто засвар эрхэлдэг байгууллагууд автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ бүртгэлжүүлж байгаад хяналт тавин ажилласан, Авто үйлчилгээний ангилал тогтоолгох хүсэлтийг www.e-mongolia.mn веб сайтаар хүлээн авч ажиллаж байна.




***Зураг №19*** *WWW.E-MONGOLIA.MN САЙТААР ХҮСЭЛТ ЯВУУЛАХ*

2023 оны жилийн эцсийн байдлаар авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санд тус онд ангилал тогтоолгосон 131 байгууллагын, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оноосон нэр, үйлчилгээний төрөл, хаяг байршлын мэдээллийг www.transport.ub.gov.mn веб сайтад байршуулсан.

Мөн www.autobox.mn сайтад нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг 120 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 22449 автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ идэвхтэй тогтмол бүртгэлжүүлсэнд хяналт тавин ажилласан.




***Зураг №20*** *Авто үйлчилгээний мэдээллийн сан*

Нийслэлийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/987 дугаар “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамж батлагдаж захирамжийн биелэлтийг 14 хоног тутамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. “Онлайн бизнес төв”-өөр 2023 оны жилийн эцсийн байдлаар 84 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч, биет болон цахимаар шийдвэрлэсэн 65, хугацаатай үүрэг даалгавар өгсөн 12, утас холбогдохгүй /аваагүй/ 19, зөвлөн туслах үйлчилгээг 38 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлсэн болно.




***Зураг №21*** *Нийслэлийн дундын мэдээллийн сан www.autobox.mn*

Арга хэмжээ №3.7 Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандарт, дүрэм, журмыг мөрдүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ, автотээврийн хяналтын улсын байцаагчтай хамтарсан шалгалт явуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авах.

Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх үзлэг шалгалтын удирдамж”-ийн дагуу Нийслэлийн

төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан.



БАТЛАВ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН
ГАЗРЫН ДАРГА
..................
С.ЖАВХЛАНТБААТАР
2023.он 05.сар 01.өдөр

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙХ ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 25 Улаанбаатар хот

Нэг.Зорилго

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад "Автотээврийн тухай" хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Авто үйлчилгээ, Ангилал. Ерөнхий шаардлага MNS5025:2020, "Автомашины угаалгын үйлчилгээ, Ангилал. Ерөнхий шаардлага" MNS 5347:2003, "Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6969:2022, "Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6970:2022, "Автотээврийн хэрэгслийг тос, тосолгооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6971:2022 стандартын хэрэгжилтийг хангуулахад оршино.

Хоёр.Хамрах хүрээ

Нийслэлийн Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт байршилтай авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид.

Гурав. Бүрэлдэхүүн, хугацаа

3.1.Нийтийн тээврийн газрын авто үйлчилгээ хариуцсан ажилтан, автотээврийн хяналтын улсын байцаагч нар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн авто засвар, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд болон шаардлагатай тохиолдолд бусад холбогдох эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцоно.

3.2.Хяналт шалгалтыг 0193УНУ улсын дугаартай тээврийн хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ. /Шатахууныг ажлын гүйцэтгэлээр тооцно/

3.3.Хяналт шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 07-ний өдрийн хооронд 6 үе шаттай хийнэ. Үүнд:

1-р үе шат:2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 04-ний өдрүүдэд 4 хоног хийнэ./Хан-Уул дүүрэгт/

2-р үе шат:2023 оны 05 дугаар сарын 08-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд 4 хоног хийнэ./Баянгол дүүрэгт/



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР
Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу 15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас : www.transport.ub.gov.mn

2023.05.03 № 01/04/990
танай ________ -ны № ________ -т

ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Хамтран ажиллах тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Автотээврийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх үзлэг шалгалтын удирдамж"-ийн хүрээнд үзлэг шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт 6 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Иймд тухайн дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдах үзлэг шалгалтад хамтран ажиллах албан хаагчдыг хуваарийн дагуу оролцуулна уу.

Үзлэг шалгалтын ажлын нэгдсэн удирдамжийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

Нийслэлийн нийтийн тээврийн газар
Газрын дарга
Дарга
Санжаа ЖАВХЛАНТБААТАР
2023.05.03 17:12

***Зураг №22*** *Үзлэг шалгалтын ажлын нэгдсэн удирдамж*

Тайлант хугацаанд Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдэд Авто угаалга, Авто засвар болон Вьетнам засварын үйлчилгээ эрхлэгч 78 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаа.

Дээрх ажлын хүрээнд Автотээврийн улсын байцаагчийн хяналтын хуудсаар шалган эрсдэлийн түвшинг тогтоон, "Эрсдэлийн түвшин өндөр" гэж үнэлэгдсэн буюу авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоож журмыг хангаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах стандарт, журмын дагуу бичиг баримтыг бүрдүүлж, авто үйлчилгээний ангилал тогтоолгох талаар зөвлөгөө өгч мэдээллээр ханган ажилласан.






***Зураг № 13*** *Баянзүрх дүүрэгт Авто тээврийн хяналтын улсын байцаагч, Үйлдвэрлэл, инноваци,*

*авто засвар хариуцсан мэргэжилтэн хамтран үзлэг шалгалт хийж буй хэсэг*

Арга хэмжээ №3.8 Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад "Зөвлөн туслах" үйлчилгээ үзүүлэх./ХТ 5.5/, Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох ажлыг эрчимжүүлэх. /ХТ 5.6/

А."Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх

ажлын удирдамж" 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан. Сургалтыг дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад Баянгол дүүргийн 32 хороодын хэсгийн ахлагч нар болон авто үйлчилгээ эрхэлж буй 67 иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдсан.

БАТЛАВ.
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ
2023 он 11 сар 07 өдөр

БАТЛАВ.
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
Д.ЖАРГАЛСҮРЭН
....он ......сар ......өдөр

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023 оны 11 дүгээр сарын 03 Улаанбаатар хот

Нэг. Зөвлөн туслах үйлчилгээний зорилго, үндэслэл

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад "Автотээврийн тухай" хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Авто үйлчилгээ, Ангилал. Ерөнхий шаардлага MNS5025:2020, "Автомашины угаалгын үйлчилгээ, Ангилал. Ерөнхий шаардлага" MNS 5347:2003, "Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6969:2022, "Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6970:2022, "Автотээврийн хэрэгслийг тос, тосолгооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 6971:2022 стандартын хэрэгжүүлэх ажиллах талаар эрх зүйн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахад оршино.

Хоёр.Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах обьектын нэр:

1. Баянгол дүүргийн 32 хорооны зохион байгуулагчид авто үйлчилгээнд мөрдөх стандарт, дүрэм, журмын талаарх сургалтыг дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 10:00-12:00 цагт зохион байгуулах.

2. Авто үйлчилгээний ангиллаа тогтоолгож, гэрчилгээгээ авсан авто үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад гэрээний үүргийн биелэлтийг шалгаж, гарсан ололт амжилт, алдаа дутагдалд зөвлөн туслах үйлчилгээг 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулна.

3. Баянгол дүүрэгт ангиллаа тогтоолгохгүй үйл ажиллагаа эрхлэж байгаа авто завсар, авто угаалга, кузов засварын газруудад үзлэг шалгалтыг 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 17 -ны өдрийн хооронд хийж стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөн туслах үйлчилгээ өгөх; ( мэдэгдэл өгөх)

Гурав. Бүрэлдэхүүн, хугацаа

3.1.Нийтийн тээврийн газрын авто үйлчилгээ хариуцсан ажилтан, автотээврийн хяналтын улсын байцаагч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн авто засвар, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн болон шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцоно.

3.2.Зорчигч тээвэр үйлчилгээний хэлтсийн 0193УНУ улсын дугаартай тээврийн хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ. /Шатахууныг ажлын гүйцэтгэлээр тооцно/

3.3.Хяналт шалгалтын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хийнэ.

Дөрөв. Хийгдэх ажил

4.1.Нийтийн тээврийн газрын Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн авто үйлчилгээ хариуцсан ажилтан, Автотээврийн хяналтын улсын байцаагч, нар 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн А/89 дугаар тушаалаар батлагдсан 4.1.2.Автотээврийн хэрэгслийн "авто засвар" үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.1.3.Авто тээврийн хэрэгслийн "кузов засвар" үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.1.4.Автотээврийн хэрэгслийн "авто угаалга" үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.1.5.Автотээврийн хэрэгслийн "резин дугуй" засвар үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-даар тус тус шалган холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

4.2.Уг удирдамжийн хүрээнд хийсэн шалгалтын тайланг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн дотор шалгалтын дүнг нэгтгэж дуусгах. байна.

4.3.Авто үйлчилгээ эрхлэгчид нь дараах чиглэлийн дагуу шалгуулна.

Үүнд: Авто үйлчилгээ-Ангилал, Ерөнхий шаардлага MNS 5025:2020 "Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага" MNS 5347:2003, "Автомашины зогсоол-ангилал, ерөнхий шаардлага" MNS 5342:2007,"Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо-тодорхойлолт" Ерөнхий шаардлага MNS 4601:2011 стандартын хэрэгжилт улсын бүртгэлийн гэрчилгээ, ангиллын гэрчилгээ, тухайн дүүрэгтээ бүртгүүлж QR авсан байх, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, холбогдох бичиг баримт;

Тав. Үр дүнг танилцуулах

5.1. Баянгол дүүрэгт авто үйчилгээ эрхлэгч байгууллагуудад хийсэн зөвлөн туслах үйлчилгээний талаарх нэгдсэн дүн мэдээг байгууллагын удирдлагад танилцуулна.

ХЯНАСАН: АЧАА ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.НЯМСАН

БОЛОВСРУУЛСАН: АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН С.АГВААНДАНЗАН






***Зураг№ 24*** *Баянгол дүүргийн Авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээний удирдамжийн хүрээнд дүүргийн хороодын хэсгийн ахлагч нарт зөвлөгөө өгч байгаа хэсэг*

Удирдамжийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 17-ны өдрүүдэд авто засвар, авто угаалга, кузов засварын 44 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шалгах хяналтын хуудсаар үзлэг, шалгалт хийж ажилласан. Шалгалтаар ангиллаа тогтоолгохгүй авто үйлчилгээ эрхлэж байсан 38 байгууллагуудад стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөх туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан.




***Зураг №25***

*Баянгол дүүрэгт хяналт шалгалтын үер авто угаалгын газарт зөвлөн туслах үйлчилгээ өгч буй хэсэг*

Саарал усны тоног төхөөрөмж ашигладаг иргэн, аж ахуй нэгж байгууллын мэдээллийг / хавсралт3/

2023 оны жилийн эцсийн байдлаар авто угаалгын чиглэлээр ангиллын гэрчилгээ авсан иргэн, аж ахуй нэгж байгууллын мэдээллийг / хавсралт4/

Сургалтад хамрагдсан 32 хороодын хэсгийн ахлагч нар болон авто үйлчилгээ эрхэлж буй 67 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад “Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан хууль, эрх зүйн эмхэтгэл” болон гарын авлага тарааж авто үйлчилгээ эрхлэгчд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.




***Зураг №26*** *Авто үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан эрх зүйн эмхэтгэл, гарын авлага*

## ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны сар бүрийн үр дүнгийн мэдээг нэгтгэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ийн захидал харилцааны дэд системээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан Ахлах мэргэжилтэн Б.Мишигдоржид хүргүүлсэн.

### *2.1 Орлогын төлөвлөгөөг улирал бүрээр батлуулан мөрдүүлэх ажлын хүрээнд:*

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам шинэчлэн батлах тухай”-ын 2.3 дугаар заалтын дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн орлогын зорчилтын судалгааг нэгтгэн холбогдох тооцооллыг хийж 2023 оны 1 улиралын орлогын төлөвлөгөөг 1 дүгээр улиралд **7,630,831,577** төгрөг төвлөрүүлэхээр боловсруулан танилцуулсан боловч Нийслэлийн Засаг даргын тамгын газраас дээрх төлөвлөгөөг 20%-иар нэмэгдүүлэн батлуулах чиглэл өгсөн. Энэ чиглэлийн дагуу орлогын төлөвлөгөөг 20%-иар нэмэгдүүлэн буюу **9,174,187,977** төгрөг байхаар 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнгээр батлуулсан.

Мөн 2 дугаар улиралын орлогын төлөвлөгөөг **9,248,621,805** төгрөг төвлөрүүлэхээр боловсруулсан боловч мөн Нийслэлийн Засаг даргын тамгын газраас дээрх төлөвлөгөөг 15%-иар нэмэгдүүлэн батлуулах чиглэл өгсөн. Энэ чиглэлийн дагуу орлогын төлөвлөгөөг 15%-иар нэмэгдүүлэн буюу **10,600,299,518** төгрөгөөр батлуулсан. Гуравдугаар улирлын орлогын төлөвлөгөөг 9,948,192,653 төгрөг байхаар 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, дөрөвдүгээр улирлын орлогын төлөвлөгөөг 10,625,088,263 төгрөг байхаар 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнгээр батлуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагад албан бичгээр хүргүүлэн ажилласан.

2019 оны тайлант хугацааны зорчигчын тоог 2018 оны мөн үетэй харьцуулахад **-16** хувиар, 2020 оны тайлант хугацааны зорчигчийн тоог 2019 оны мөн үетэй харьцуулахад **-30** хувиар,

2021 оны тайлант үеийг 2020 оны мөн үетэй харьцуулахад **-33** хувиар тус тус буурсан байна. Харин 2022 оны орлогыг 2021 оны мөн үетэй харьцуулахад **63%**-иар өссөн үзүүлэлттэй байна. Дээрх 5 жилийн дундаж хувь нь **-4%** байна.




1.




## 2.2 Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/1620 дугаар захирамж, Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын 2022 оны А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 136, 02 дугаар сард 88 нийт 224 автобусаар парк шинэчлэлт хийж Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т тус бүр 112 автобусыг хүлээлцүүлэх ажлыг

зохион байгуулж,
2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс үе шаттайгаар үйлчилгээнд гаргаад байна.

Мөн SkyWell маркын их багтаамжийн цахилгаан 55 автобусыг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч, 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчилгээнд гаргаад байна.

2023-2024 онд улсын төсвийн хөрөнгөөр их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600, цахилгаан хөдөлгүүртэй 160, дунд багтаамжийн 50, нийт 810 автобус, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон "Тэнүүн-Огоо" ХХК-ийн хооронд байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 дугаартай, 2023 оны 02 дугээр сарын 10-ны өдөр байгуулсан ННТГ23001-01 нэмэлт гэрээ "Нийтийн тээврийн автобус худалдан авах гэрээ"-ний дагуу нийт 125 автобус, 10 цэнэглэх төхөөрөмж хүлээн авч гэрээний дагуу нийлүүлэгдсэн.

Дунд багтаамжийн Hyundai County CS маркын 50ш автобус гаалийн Интердесижн ХХК агуулахад хадгалагдаж байна.

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны А/98 дугаар тушаалаар "Нийтийн тээврийн автобус худалдан авах их багтаамжийн автобусны техникийн үзүүлэлт боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулан Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.

Нийслэлийн засаг Даргын тамгын газраас нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр нийтийн тээврийн их багтаамжийн автобус худалдан авах тендерийг зарласан.

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 10.00 цагт Нийслэлийн засаг Даргын тамгын газрын "Хангарьд" ордонд тендерийг нээлттэй задлахад гадны таван компани саналаа ирүүлснээс Yutong Bus компани 165.5 тэрбум төгрөгийн үнийн саналаар шалгарч НЗДТГ/202310014 дугаартай Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ байгуулсан.

Тус компани нь 2023 оны оны 12 дугаар сард их багтаамжийн дизель евро-5 хөдөлгүүртэй автобус 35, 2024 оны 1 дүгээр сард 565 автобус, нийт 600 ширхэг нийтийн тээврийн автобус нийлүүлэхээр Yutong Bus компанитай гэрээний дагуу ажиллаж байна.

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/88 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн газрын "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг нэгтгэн, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/01/1188 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Мөн байгууллагын Хууль, дүрмээр хүлээсэн үүрэг болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа ажлын биелэлтийг нэгтгэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн О.Мандах-д mandakh@ulaanbaatar.mn цахим хаягаар хүргүүлсэн

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай тус газрын даргын байгуулах гэрээний төсөл, гэрээний хавсралт болох "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар

тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу: Бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 9 зорилт, 73 арга хэмжээ тусган боловсруулж Нийтийн тээврийн газрын 7 хэлтэс, нэгжийн дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс Хяналтын дагалдах хуудсаар санал авч, “Ажлын хэсэг”-ийн хуралд тус газрын дарга С.Жавхлантбаатар танилцуулан, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлуулсан.

2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хариуцлагын гэрээний хэрэгжилт, түүний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны нэгдүгээр улирлын байдлаар гарган НЗДТГ-т 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/01/859 дугаартай албан бичгээр, 2023 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/01/1171 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэн, 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-ын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.

-2023 оны гуравдугаар улирлын биелэлтийг нэгтгэн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Нийтийн тээврийн газрын даргад танилцуулан, гүйцэтгэлийг Erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын системээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн О.Мандахад хүргүүлсэн.

## 1. *Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа*

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/844 дүгээр захирамжаар 350 орон тоотой байхаар батлагдсан. Өнөөдрийн байдлаар төрийн захиргааны 31, төрийн үйлчилгээний 116 албан хаагч ажиллаж байна.

Тайлант хугацаанд ажилд томилох тухай-53, Шилжүүлэн ажиллуулах тухай-9, Үргэлжлүүлэн ажлуулах тухай-2, Ажлаас чөлөөлөх тухай-22, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, Түр орлон гүйцэтгүүлэх тухай-1, Чөлөө олгох тухай-14, Тэтгэмж олгох тухай-4, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-5, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн тогтоох тухай-1, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-7, Ахмадын бүртгэлд авах тухай-5, тушаал хүчингүй болгох тухай-2, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай-1, нийт 157 тушаал шийдвэрийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргаад байна.

2023 оны төрийн захиргааны 39 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, төрийн үйлчилгээний 118 албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллалаа.

Байгууллагын албан хаагчдын цаг ашиглалт, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ERP дотоод удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй албан хаагчдын хагас жилийн цаг бүртгэлд хяналт хийсэн. Мөн цаг бүртгэлийн системд бүртгэх боломжгүй чиг үүргийг хэрэгжүүлдэг Автотээврийн хяналтын улсын байцаагч, Шалгагч, Техникийн хяналтын үзлэгийн төвийн албан хаагчдын цаг бүртгэлийг google ашиглаж хяналт тавьж ажиллаж байна.

### АЛБАН ХААГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Монос” ХХК-тай хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж нийт 70 албан хаагчийг хамруулсан. 2023 оны 05 дугаар сарын 18,19-ний өдрүүдэд “Оточ одь” ХХК-тай хамтран нийт албан хаагчдад эрүүл мэндийн боловсрол олгох 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 88 албан хаагчийг хамруулаад байна.




## АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ҮЕ ШАТТАЙГААР САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Нийтийн тээврийн газрын даргын 2022 оны А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу албан хаагчдаас ирсэн хүсэлтийг үндэслэн тэтгэмж олгох тухай-4, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-5, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн тогтоох тухай-1, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-7, Ахмадын бүртгэлд авах тухай-5 асуудлыг шийдвэрлэж тус тус ажиллалаа. Мөн Хөдөлмөрийн тухай хууль, өдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын дагуу эхний хагас жилийн байдлаар 73 албан хаагчийн амралтын мэдэгдлийг гаргаж, мэдэгдлийн дагуу 29 албан хаагчийн ээлжийн амралтыг хуваарийн дагуу биеэр эдлүүлж байна.

## АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ УР ЧАДВАР, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Тээврийн цагдаагийн албатай хамтран аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 5 албан хаагчийг хамруулаад байна.

Албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан сургалтуудад хамруулж ажиллалаа. Мөн байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан дотооддоо  архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтуудад үе шаттайгаар хамруулж байна.

| № | Огноо | Сургалтын нэр | Хамрагдсан албан хаагчид | Хаанаас |
|---|---|---|---|---|
| 1 | 2023/02/01 | “BRMS” програмын сургалт | М.Батцэцэг | “Улаанбаатар смарт карт” ХХК |
| 2 | 2023/02/09 | Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин /цахим/ | Бүх албан хаагчид | Төрийн албаны зөвлөл |
| 3 | 2023/01/12 | ХАСХОМ сургалт | ТЗ-ны албан хаагчид | Төрийн албаны зөвлөл |
| 4 | 2023/02/09 | Худалдан авах ажиллагааны сургалт | Б.Галбадрах | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | 2023/02/13-14 | Тээврийн мэдээллийн системийн мэдлэг түгээх | Б.Галбадрах | Зам тээврийн хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкны Тээврийн мэдээллийн системийг хөгжүүлэх техникийн туслалцааны баг |
| 6 | 2023/02/25 | Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт | ТЗ, ТҮ-ний албан хаагчид | Бичиг хэрэг, архивын зааварлагч Н.Гэрэлмаа |
| 7 | 2023/02/28 | Excel сургалт | албан хаагчид | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга З.Цэвээндорж |
| 8 | 2023/03/02 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих | албан хаагчид | Төрийн албаны зөвлөл |
| 9 | 2023.04.11 | “Газар хөдлөлт”, ”Галын аюул” гамшгаас хамгаалах сургалт | албан хаагчид | Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газраас |
| 10 | 2023.04.11 | Чанарын менежментийн ISO стандарт хэрэгжүүлэх | З.Цэвээндорж, А.Оргилсайхан, Б.Тамир, О.Хонгорзул, Ч.Ариунтуяа, Б.Баярмаа, Мягмар | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас |
| 11 | 2023.04.12 | Динамик график төлөвлөлт | Э.Анхбаяр, М.Батцэцэг, Б.Галбадрах | УБСК |
| 12 | 2023.05.10 | Манлайлал | О.Хонгорзул, А.Оргилсайхан, Б.Бадамдорж | Хүний нөөцийн хөгжлийн төв |
| 13 | 2023.05.16 | Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт | ЗУХ, ТэТХ-ийн албан хаагчид | Төрийн албаны зөвлөл |
| 14 | 2023.05.25-26 | Үр дүнд суурилсан удирдлага”-ын сургалтад 2023 оны 05 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд хамрагдсан. | Б.Даваадолгор, Б.Болорцэцэг | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас |
| | 2023. 05.05 | Цахим орчин дахь боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь | ЗУХ-ийн албан хаагчид | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас |
| 15 | 2023.05.30 | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг | Б.Болорцэцэг Г.Цолмонгэрэл | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас |















*2.*

*Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, архив, албан хэрэг хөтлөлт*

**Албан хэрэг хөтлөлт, EDOC програм ашиглалтын талаар:**

12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол улсын Засгын газрын 246 тогтоол “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг, 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/111 захирамж “Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам батлах тухай”, 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/52 “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ыг erp.ulaanbaatar.mn/ байршуулан албан хаагчдад мэдээлэл өгч ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар ирсэн 3618 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж хангалтгүй шийдвэрлэсэн-101, болон үг үсгийн алдаатай-17 албан бичгийг цуцлан дахин шийдвэрлүүлэв.

- 88 албан бичигт дахин хяналт хийсэн.

Ирсэн 1725 өргөдөл, гомдлыг журамд заагдсан хугацаанд хүлээн авч, 1684 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж 2023 оны жилийн эцсийн байдлаар 175 зөрчил тооцогдсон байгаагаас өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил-83, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил-37, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил-52, холбогдох файл хавсаргаагүй зөрчил-1, буцаалтыг 3-аас дээш хоногт хийсэн зөрчил-1 байгаад дүгнэлт хийж 7 хоног бүрийн 5 дахь өдөр явцын тэмдэглэл хөтлөх, өдөрт нь багтаан хүлээн авах чиглэл өгч ажиллаж байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хариуг иргэний талд шийдвэрлэсэн 1215, боломжгүй тухай хариу өгсөн 447, албан бичгээр болон иргэнтэй биечилж уулзаж хариу өгсөн 187, бусад хэлбэрээр хариу өгсөн 13 өргөдөл, гомдол байна. Мөн байгууллагад хүний нөөцийн чиглэлээр ирсэн 131 өргөдөл, гомдлыг  цаг тухай бүр шийдвэрлэн ажилд авах, чөлөөлөх, чөлөө олгох, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр Газрын даргын 123 тушаал гарч өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллалаа. Ирсэн 2975 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж хангалтгүй шийдвэрлэсэн-94, болон үг үсгийн алдаатай 16 албан бичгийг цуцлан дахин шийдвэрлүүлэв. 82 албан бичгийг дахин хянасан.




**2023 оны эхний хагас жилийн ирсэн албан бичгийг**
**2022 оны мөн үетэй харьцуулбал:**

| Д/Д | 2022 он | 2023 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 3881 | 3954 | 73 |



### 3. Ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг алба, хэлтсүүдийн дүнгээр үзүүлбэл:

| № | Зохион байгуулалтын нэгж | Нийт ирсэн бичгийн тоо | Хариугүй | Хариутай | Хугацаандаа шийдвэрлэгсэн бичгийн тоо | Шийдвэрлэх шатандаа байгаа бичгийн тоо | Хугацаа хэтэрэн шийдвэрлэгдсэн бичгийн тоо | Хугацаа хэтэрэн, огт шийдвэрлээгүй бичгийн тоо | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоногоор/ | Нийт ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлага | **34** | **28** | **6** | **3** | **18** | **0** | **0** | **1,64** | **100%** |
| 2 | Захиргаа удирдлага, хэлтэс | **544** | **371** | **173** | **518** | **14** | **12** | **0** | **5,94** | **97,8%** |
| 3 | Тээвэр төлөвлөлтийн хэстэс | **563** | **429** | **134** | **552** | **11** | **0** | **0** | **8,61** | **100%** |
| 4 | Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс | **1978** | **1813** | **165** | **1953** | **23** | **2** | **0** | **3,24** | **99,7%** |
| 5 | Хяналт шалгалтын хэлтэс | **198** | **187** | **11** | **1** | **4** | **0** | **0** | **7,29** | **100%** |
| 6 | Техник технологийн хэлтэс | **261** | **227** | **34** | **258** | **0** | **3** | **0** | **5,89** | **99,8%** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Ачаа тээвэр логистикийн хэлтэс | **109** | **89** | **20** | **107** | **1** | **1** | **0** | **3,7** | **99,5%** |
| 8 | Техникийн хяналтын үзлэгийн төв | **26** | **22** | **4** | **23** | **3** | **0** | **0** | **7,58** | **100%** |
| 9 | Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс | **240** | **195** | **45** | **232** | **6** | **2** | **0** | **6,85** | **98,1%** |
| 10 | Орлого төвлөрүүлэлтийн тасаг | **1** | **1** | **0** | **1** | **0** | **0** | **0** | **18** | **100%** |
| | Байгууллагын дүн | **3954** | **3362** | **592** | **3853** | **81** | **20** | **0** | **5** | **99,1%** |

**Ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийсэн талаар:**

Ирсэн 3729 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж хангалтгүй шийдвэрлэсэн-103, болон үг үсгийн алдаатай-18 албан бичгийг цуцлан дахин шийдвэрлүүлэв.

- 90 албан бичгийг дахин хянсан.




**Ирсэн бичигт хийсэн хяналтын харьцуулалт**

| Д/Д | 2022 он | 2023 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 3750 | 3729 | -21 |




**Гадны байгууллагад явуулсан бичиг:**

Гадны байгууллагад явсан 2444 албан бичгийн хэвлэмэл хуудсанд буулгасан.

Гадны байгууллагад явуулсан албан бичгийг тоон гарын үсэг зурж баталгаажсаны дараа тус байгууллагуудад цаг тухайд нь илгээж ажилласан.

Гадны байгууллагад явуулсан 126 хуудас 110 албан бичгийг сканердаж eDoc програмд шивж оруулан тухайн байгууллагуудад нь шилжүүлсэн. 362 албан бичигт бүртгэл үйлдэн хаяглаж шуудангаар хүргүүлэн ажиллаж байна.



**2023 оны жилийн явсан албан бичгийг**

**2022 оны мөн үетэй харьцуулбал:**

| Д/Д | 2022 он | 2023 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 1539 | 2444 | 905 |







**2023 оны жилийн баримт бичгийн**

**эргэлтийн хэмжээг тооцоолбол**

| д/д | Баримт бичиг | Баримт бичгийн тоо | | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | | Эх хувь | Хуудасны тоо | Сканердсан | |
| 1 | Ирсэн баримт бичиг | 1967 | 3934 | 1377 | |
| 2 | Явуулсан баримт бичиг | 1132 | 2264 | 126 | |
| 3 | Төсөл, төлөвлөгөө, тайлан, тушаал, захирамж, протокол, гэрээ, акт зэрэг дотоодын баримт бичиг | 414 | 828 | 1044 | 2286 |
| **Дүн** | | | | | |

**Өргөдөл гомдол:**

Байгууллагад ирсэн 14 хуудас 14 өргөдлийг скайнердаж файл үүсгэн erp.ulaanbaatar.mn програмд шивж /edoc.ulaanbaatar.mn/ прорамаар ирсэн 103 өргөдөл гомдлыг шилжүүлж ажилласан.

**Байгууллагын хэвлэмэл хуудас ашиглалтын талаар:**

2023 оны хэвлэмэл хуудсуудыг ашиглалтад бэлтгэн, төрлөөр нь ялгаж дугаарлан ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, бүртгэлийн тэмдэг дардсыг зааврын дагуу Тушаал, А4, А5 хэвлэмэл хуудасны бүртгэлийн тэмдэг дардсыг даран дугаарласан. (А5-1-1696-1696Ш А4-1-1670-1670Ш Тушаал--1-891-891ш) А4-1000ш, А5-1000ш https://edoc.ulaanbaatar.mn/- програмаар захиалж хэвлүүлсэн. Хэвлэмэл хуудасны бүртгэл хөтлөж ажилласан.

2022 оны хүчингүй болгосон хэвлэмэл хуудас А5-7ш, А4-19ш, тушаал-44ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт-14ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага-11ш, 2023 оны 03 дугаар сарын 14-ний А/28 тушаалаар хүчингүй болгосон.



**2023 оны хэвлэмэл хуудасны тооцоо**

| д/д | Нэр төрөл | Захиалж авсан | Нийт | Зарцуулсан | Хүчингүй болгосон | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | А-4 | 1000 | 1736 | 1624 | 73 | 112 |
| 2 | А-5 | 1000 | 1978 | 1662 | 30 | 316 |
| 3 | Тушаал | 1000 | 1534 | 857 | 15 | 677 |
| 4 | Албан даалгавар | 0 | 498 | 0 | 0 | 498 |
| 5 | Хурлын тэмдэглэл | 0 | 474 | 44 | 21 | 430 |
| 6 | Гадаад харилцаа | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | АТХУБ дүгнэлт | 1000 | 1495 | 428 | 152 | 1067 |
| 8 | АТХУБ албан шаардлага | 0 | 395 | 154 | 22 | 241 |
| 9 | АТХУБ Акт | 0 | 404 | 0 | 0 | 404 |
| **Дүн** | | **4000** | **8514** | **4769** | **313** | **3745** |

**2023 оны хүчингүй болгосон хэвлэмэл хуудас**

| д/д | Нэр төрөл | Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны индекс | Тоо |
|---|---|---|---|
| 1 | Тушаал | 22, 23, 26, 27, 32, 33, 57, 58, 59, 60, 61, 62, 73, 74, 177, 181, 194, 195, 207, 208, 229, 230, 260, 261, 279, 280, 309, 310, 318, 319, 398, 399, 400, 401, 444, 445, 455, 456, 476,477, 566, 567, 679, 680, 696, 697, 705, 706, 707, 708, 710, 713, 714, 742, 743, 744, 745, 761, 762, 763, 764, 817, 818, 843, 844, 845, 846, 847, 848, 865, 866, 875, 876 | 73 |
| 2 | Хурлын тэмдэг | 4, 8, 10, 11, 12, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 22, 23, 31, 34, 35, 36, 37 дугаарлаагүй -2 | 22 |
| 3 | Албан бичиг (А5) | 104, 129, 483, 484, 488, 959, 960, 961, 962, 963, 1046, 1047, 1106, 1176, 1203, | 15 |
| 4 | Албан бичиг (А4) | 41, 61, 62, 67, 104, 114, 115, 118, 330, 377, 507, 508, 511, 512, 513, 514, 515, 516, 525, 526, 533, 534, 792, 793 848, 925, 1076, 1077 | 28 |
| 5 | АТХУБ дүгн | 04, 05, 48, 49, 50, 51, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 113, 114, 117, 118, 131, 134, 135, 144, 145, 146, 147, 148, 149, 160, 181, 183, 184, 189, 190, 412, 413, 213, 296, 313, 344, 345, 379, 434, 435, 436, 437, 438, 439, 440, 441, 442, 443, 444, 445, 446, 447, 448, 449, 450, 451, 452, 453, 454, 455, 456, 457, 458, 459, 460, 461, 462, 463, 464, 465, 466, 467, 468, 469, 470, 471, 472, 473, 474, 475, 476, 477, 478, 479, 480, 481, 482, 483, 484, 485, 486, 487, 488, 489, 490, 491, 492, 493, 494, 495, 496, 497, 498, 499, 500, 501, 502, 503, 504, 505, 506, 507, 508, 509, 510, 511, 512, 513, 514, 515 | 149 |
| 6 | АТХУБ Албан шаардлага | 19, 20, 21, 22, 25, 26, 31, 32, 37, 38, 39, 40, 43, 44, 45, 46, 49, 120, 123, 124 | 20 |
| Нийт | | | 307 |

**Сургалтын талаар:**

Нийслэлийн хэмжээнд  тоон гарын үсгээ ашиглан албан бичгээ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад илгээх, хариу хүлээн авах, хянах, болсонтой

холбогдуулан албан хаагчдад www.edoc.ub.gov.mn програм дээр баримт боловсруулах талаар  мэдээ, мэдээллийг  өгч ажиллав.

Байгууллагын нийт албан хаагчид албан хэрэг хөтлөлтэй холбоотой журмыг дагаж мөрдүүлэх, Удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах, албан бичиг баримтыг эмхлэн бүрдүүлэх, өөрийн үйл ажиллагааны явцад үүсэх баримтыг хадгалж, баримт бичигтэй ажиллах ажлыг зохион байгуулах дэг, горимыг  баримталаж ашиглах талаар албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлт, програм ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлт, хугацаанд нь шилжүүлэх, шийдвэрлэх зөрчлийг бууруулах, шийдвэрлэлтийн дундаж хоног бууруулах талаар мэдээлэл өгч ажилласан.

-2023 оны 01 дүгээр  сарын 25-д шинээр ажилд орсон 9 албан хаагчдад “Албан хэрэг хөтлөлт”, https://edoc.ulaanbaatar.mn/ ашиглалтын талаар сургалт зохион байгуулсан.

-2023 оны 02 дугаар сарын 28-д Байгууллагын 14 албан хаагчдад Албан хэрэг хөтлөлт, програм ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар сургалт зохион байгуулсан.




-2023 оны 02 дугаар сарын 28-д Нийтийн тээврийн үндсэн чиглэл болон такси үйлчилгээ эрхлэгч 17 аж ахуйн нэгж байгууллагуудын 18 албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулсан.




-2023 оны 04 дүгээр сарын 26-д Байгууллагын 13 албан хаагчдад Албан хэрэг хөтлөлт, програм ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар сургалт зохион байгуулсан.




-2023 оны 04 дүгээр сарын 27-д Нийтийн тээврийн үндсэн чиглэлийн үйлчилгээ эрхлэгч 12 аж ахуйн нэгж байгууллагуудын 14 албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулсан.





2023 оны 09 дүгээр сарын 27-д Байгууллагын 6 хэлтсийн 17 албан хаагчдад Албан хэрэг хөтлөлт, програм ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар сургалт зохион байгуулж тестээр шалгалт авсан. 17 албан хаагчдаас шалгалт авахад дүнгийн голч нь 13,3 буюу 66,6%




-2023 онд байгууллагын албан хаагчид болон харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудад Архив албан хэрэг хөтлөлт болон програм ашиглалтын талаар нийт 5 удаа сургалт зохион байгуулсан.

-Байгууллагын нийт албан хаагчид болон шинээр ажилд орсон албан хаагчдад програм болон албан хэрэг хөтлөлтөөр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

2023 оны 04 дүгээр сарын 10-д Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газаар зохион байгуулсан “Анзаар аян” сургалт;

2023 оны 05 дугаар сарын 03-д Нийслэлийн хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт edoc систем ашиглалт” сургалтад цахимаар;

Нийслэлийн засаг даргын тамгын газрын хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Цахим орчин дахь ажлын бүтээмж нэмэгдүүлэх сургалтад цахимаар;

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар Азийн хөгжлийн банк, Ай ти ви зөвлөх үйлчилгээтэй цахимаар зохион байгуулсан уулзалтад оролцсон.

**Нөхөн бүрдүүлэлтийн талаар:**

2023 оны 01 дүгээр улиралд 2022 оны баримтыг эмхэлж цэгцлэх, үдэж хавтаслах, дотоод товъёог үйлдэх, баталгаа болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас бичих зэрэг техник боловсруулалт хийж Явуулсан албан бичиг 44 боть, Дээд газраас ирсэн бичиг-4 боть, Харилцагч бусад байгууллагаас ирсэн бичиг-16 боть, Дээд газраас ирсэн захирамж тогтоол-1, Дээд газраас ирсэн хурлын тэмдэглэл, тушаал-1, Албан даалгавар-1 боть, Албан даалгаврын саналын хуудас-1 боть, Бичиг хэргийн ажилтны тайлан-1, Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт-1, бүртгэлийн дэвтэр-6, Ирсэн бичгийн бүртгэл хяналтын карт-2, Ирсэн бичигт хяналт хийсэн бүртгэл-2, ирсэн бичгийн шийдвэрлэлийн мэдээ-1 боть, А-тушаалын саналын хуудас 4 боть, Б.Тушаалын саналын хуудас 3 боть, Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтад хийсэн тооцоо-1 боть, Баримт бичгийн эргэлтийн мэдээ-1 боть, байнга-17, түр хадгалах-73 боть нийт **90** боть баримт үдэж, хавтаслан хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивд нөхөн бүрдүүлэлт хийсэн.

2023 оны баримтыг эмхэлж цэгцлэх, үдэж хавтаслах, дотоод товъёог үйлдэх, баталгаа болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас бичих зэрэг техник боловсруулалт хийж Явуулсан албан бичиг 33 боть, Ирсэн бичиг-7 боть, А.тушаалын саналын хуудас-1, Б тушаалын саналын хуудас-3, Ирсэн бичгийн бүртгэл-1, Ирсэн бичгийн хяналтын карт-1 боть баримт үдэж, хавтаслан нийт -46 хадгаламжийн нэгж бүрдүүлсэн.

**Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудын үйл ажиллагаа, үйлчилгээний байдалд түвшин тогтоох шалгалт зохион байгуулав.**

Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/27 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг тус газартай “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээтэй ажилладаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний байдалд түвшин тогтоох шалгалтыг 03-р сарын 10-ны өдрөөс 28-ны хооронд ажлын 7 өдөр ажилласан.

Ажлын хэсэгт тус газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Хотын стандартын газар, Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбоо, Улаанбаатар смарт карт ХХК зэрэг 7 байгууллагын төлөөлөл оролцсон.





**Аттестатчиллын явцад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй байдал**

Нийслэлийн тээврийн газартай гэрээ байгуулан ажилладаг үндсэн чиглэлийн 18 аж ахуйн нэгжүүд шалгагдсанаас дараах байдалтай дүгнэгдсэн. Үүнд:

- 10 аж ахуйн нэгж байгууллага 80-аас 90 хүртэлх оноо,
- 5 аж ахуйн нэгж байгууллага 70-аас 80 хүртэлх оноо,
- 2 аж ахуйн нэгж байгууллага 60-аас 70 хүртэлх оноо,
- 1 аж ахуйн нэгж байгууллага 60-аас доош оноотой тус тус дүгнэгдсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дүгнэгдсэн байдлыг дор дурдсан хүснэгтэд харуулав.

**Түвшин тогтоох шалгалтыг 2 үндсэн үзүүлэлтээр дүгнэсэн байдал**

| д/д | Нэр | Авсан нийт оноо | Материаллаг баазын үзүүлэлтийн дүн | Үйлчилгээний байдлын үзүүлэлтийн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ | 89.05 | 53 | 36.05 |
| 2 | Эс энд эй транс ХХК | 81.04 | 46.08 | 34.96 |
| 3 | Тэнүүн-огоо гуравдугаар бааз ХХК | 86.7 | 50.37 | 36.33 |
| 4 | Тэнүүн-огоо ХХК | 87.4 | 52.11 | 35.29 |
| 5 | Эрдэм транс ХХК | 84.97 | 51.88 | 33.09 |
| 6 | Автотерминал трейд ХХК | 79.89 | 48.79 | 31.1 |
| 7 | Дюц ХХК | 76.37 | 46.06 | 30.31 |
| 8 | Үнэгтийн уул ХХК | 57.63 | 29.22 | 28.41 |
| 9 | Мяралзаа ХХК | 82.07 | 50.09 | 31.98 |
